



ХЭНТИЙ АЙМАГ
ӨМНӨДЭЛГЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 08 сарын 22 өдөр

Дугаар 5/11

Өмнөдэлгэр сум

Ур чадварын нэмэгдэл олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Төсвийн тухай хуулийн 14 дугаар зүйлийн 14.2.3. дахь заалт, Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.2.4 дэх заалт, Хөдөлмөрийн тухай хуулийн 101 дугаар зүйлийн 101.1 дэх заалт, Засгийн газрын 382 дугаар тушаалын 4 дүгээр хавсралтаар батлагдсан “Төрийн үйлчилгээний албан хаагчдад ур чадварын нэмэгдэл олгох нийтлэг журам”, Соёлын сайд, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын 2024 оны А/166, А/63, А/73 тоот хамтарсан тушаалаар батлагдсан “Соёл урлагийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагчдад ур чадварын нэмэгдэл олгох шалгуур үзүүлэлтийн 9 дэх заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн соёл урлагийн газрын 2024 оны 06 дугаар сарын 19-ны өдрийн 01/200 албан бичгийн хавсралтын дагуу Соёлын төвийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Баярбатад ур чадварын нэмэгдэл олгосугай.

2. Ур чадварын нэмэгдлийг 2024 оны 7 дугаар сарын 23-ны өдрөөс эхлэн 2024 оны 09 дүгээр сарын 27-ны өдөр хүртэл сар бүр 25 хувиар тооцож Соёлын төвийн цалингийн сангаас олгохыг нягтлан бодогч (Б.Гантулга)-д зөвшөөрсүгэй.



Б.ЭРДЭНЭБААТАР